

“Монгол Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 24/12 тоот  
тогтоолын Тавдугаар хавсралт



**“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН  
“ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ,  
ХАМТРАН АЖИЛЛАХ БОДЛОГО”**

## АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	1
ХОЁР. ОРОЛЦОГЧ ТАЛУУД .....	1
ГУРАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ .....	1-2
ДӨРӨВ. БОДЛОГЫН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ .....	2
ТАВ. ХЯНАЛТ, САЙЖРУУЛАЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ .....	2

## **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү баримт бичгийг Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн хурээнд нээлттэй хувьцаат компанийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулав.
- 1.2. Энэхүү бодлогын зорилго нь Монгол Даатгал ХК (цаашид "Компани" гэх)-ийн оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах харилцааг зохицуулахад орших бөгөөд оролцогч талуудтай харилцахдаа компанийн баримталдаг үнэт зүйлст нийцсэн үзэл баримтлал, зарчмыг мөрдлөг болгоно.

### **ХОЁР. ОРОЛЦОГЧ ТАЛУУД**

- 2.1. Оролцогч талууд гэж компанийн үйл ажиллагаанд оролцох сонирхолтой болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх чадвартай талууд (хүн ба байгууллагууд), түүнчлэн компанийн үйл ажиллагаа нь шууд болон шууд бусаар өөрсдөд нь нөлөөлж буй талуудыг хэлнэ.
- 2.2. Компани нь дараах оролцогч талын бүлгүүдтэй. Үүнд:
  - 2.2.1. Хувьцаа эзэмшигчид
  - 2.2.2. Ажиллагсад
  - 2.2.3. Үйлдвэрчний эвлэл
  - 2.2.4. Харилцагчид
  - 2.2.5. Хамтран ажиллагсад
  - 2.2.6. Гэрээт компаниуд
  - 2.2.7. Зээлдүүлэгчид
  - 2.2.8. Төрийн байгууллагууд
- 2.2.9. Төрийн бус байгууллагууд
  - 2.2.9.1. Их сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагууд
  - 2.2.9.2. Өрсөлдөгчид
  - 2.2.9.3. Хэвлэл мэдээлэл
  - 2.2.9.4. Олон нийт ба нийгмийн бүлгүүд
- 2.3. Компани нь тогтвортой өсөлтийг хангах, дунд болон урт хугацааны үнэ цэнийг бий болгоход оролцогч талуудын хувь нэмрийг хүлээн зөвшөөрч, эрх ашгийг нь хүндэтгэн, хамтран ажиллана.
- 2.4. Компани нь оролцогч талуудтай хамтран ажиллахдаа шударга ёс, ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллана.
- 2.5. Оролцогч талуудад эрсдэл, нөлөөллийн шинжилгээ хийж ангиллууд үүсгэнэ. Оролцогч талуудын хамаарал, ач холбогдлыг тодорхойлохдоо тэдний учруулж болох эрсдэл, нөлөөллийн материаллаг байдлыг харгалзан үзнэ. Тийнүү тодорхойлсон хамаарал, ач холбогдлын дагуу оролцогч талуудын ангилал бүртэй харилцах, хамтран ажиллах зарчмыг баримталж ажиллана.

### **ГУРАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ**

- 3.1. Компани нь нийгмийн сайн гишүүн байх зорилгынхoo хурээнд оролцогч талуудтай хамтран ажиллаж, нийгмийг хөгжүүлэх болон хүрээлэн байгаа орчныг хамгаалахад хувь нэмрээ оруулна.
- 3.2. Оролцогч талуудын булэг, ангилал бүр өөр өөр харах өнцөг, хүлээлттэй байдгийг анхаарч үзэн тус бүрд нь тохирсон харилцах, хамтран ажиллах стратеги, арга хэлбэр, журамтай байна.
- 3.3. Компани нь оролцогч талуудтай үр дүнтэй харилцаа холбоо үүсгэхийн тулд олон улсын сайн туршлагуудыг нэвтрүүлэн тэдэнд хамаарах санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийн ил тод байдлыг холбогдох журмын хурээнд хангаж ажиллана.
- 3.4. Оролцогч талуудтай сайн харилцаа, итгэлцэл үүсгэхийн тулд оролцогч талуудын бүлэг, ангилал бүр болон нөхцөл байдал, үргэлжлэх хугацаа, орон нутгийн соёлд тохирсон

харилцааны тодорхой стратеги, арга, хэлбэр, журмыг хэрэгжүүлэх замаар нягт харилцаж, харилцан ойлголцлыг туштай бий болгоно.

3.5. Оролцогч талуудын санаа бодол, хүлээлт, хэрэгцээг ойлгохын тулд өөрсдөд нь нөлөөлж буй асуудлуудад оролцохыг дэмжиж, тэдний санал гомдлыг хүлээн авах сувгаар хангаж, ач холбогдол өгч, санал бодлоо солилцно.

3.6. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дунтэйгээр ажиллуулна.

## ДӨРӨВ. БОДЛОГЫН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

4.1. Компанийн хөгжлийн стратегийг хариуцдаг чиглүүлэгч бүтцийн хувьд Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТУЗ“ гэх) нь оролцогч талуудын ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, тэдгээрийг зохистойгоор тэнцвэржүүлэн ажиллана.

4.2. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.

4.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтai хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.

4.4. Компани нь оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах энэхүү бодлогыг чиглэл бүрийн дурэм, журам, гэрээний заалтуудад тусгаж өгнө.

4.5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь бодлогыг хэрэгжүүлэх төсөв хуваарилж, чадварлаг, мэдлэгтэй боловсон хүчин болон оролцогч талуудаас санал авах, мэдээлэл бүрдүүлэх системээр хангана.

4.6. ТУЗ нь оролцогч талуудтай холбоотой үүсэж болох эрсдэлүүдийг тодорхойлон, тэдгээрийг удирдах чиглэлийг тогтоож, хэрэгжилтийг хангуулан ажиллана.

## ТАВ. ХЯНАЛТ, САЙЖРУУЛАЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

5.1. Энэхүү бодлогын баримт бичгийг ТУЗ-ийн шийдвэрээр өөрчилж, сайжруулж, хүчингүй болгож болно.

5.2. Энэхүү бодлогын баримт бичгийн хэрэгжилтэнд ТУЗ хяналт тавьж ажиллана.

5.3 ТУЗ нь энэхүү бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор компанийн эрх бүхий албан тушаалтан, гүйцэтгэх удирдлагад шаардлага, зөвлөмж, чиглэл хүргүүлэх, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ТУЗ-ын тогтоол гаргаж аливаа хэлбэрээр арга хэмжээ авах бүрэн эрхтэй байна.

---ooo---